



БОГД БАНК

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН



2025 оны хагас жил

www.bogdbank.com



Агуулга

Удиртгал

- 4 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- 5 Тогтвортой хөгжлийн тайлангийн тухай

Тогтвортой хөгжил

- 7 Бидний оролцоо
- 9 Ногоон банк

Байгаль орчин

- 12 Ногоон санаачилгууд
- 15 Хүлэмжийн хийн ялгарал
- 16 Нөөцийн хэмнэлт

Нийгэм

- 18 Санхүүгийн боловсрол
- 19 Санхүүгийн хүртээмж ба урамшуулалт аянгууд
- 19 Ажилтнуудын оролцоо ба дотоод соёл
- 21 Олон нийтэд мэдээлэл түгээх

Засаглал

- 24 Богд банкны Тогтвортой байдлын бодлого ба хэрэгжилт
- 25 Ил тод байдал ба тайлагнал
- 26 Байгууллагын дотоод чадавхийг хөгжүүлэх
- 26 Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээ

Удиртгал

Гүйцэтгэх Захирлын Мэндчилгээ



"Богд Банк нь урт хугацааны үнэ цэнийг хэрэглэгчид, ажилтнууд болон нийгмийнхээ төлөө бий болгоход хариуцлагатай банкны үйл ажиллагаа болоод тогтвортой өсөлтийг зайлшгүй шаардлагатай гэж үздэг билээ. Бидний Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын бодлого нь илүү тогтвортой, хүртээмжтэй ирээдүйг цогцлоохын төлөө гаргаж буй шийдвэр бүрийг чиглүүлж өгдөг юм.

Бид өөрсдийн байгаль орчинд нөлөөлж буй нөлөөллийг бууруулах зорилгоор ногоон санаачилгуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, тогтвортой санхүүжилтийг дэмжин ажилладаг. Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээрээ дамжуулан нөөцийн хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ногоон эдийн засагт хувь нэмэр оруулахыг эрмэлзсээр байна.

Нийгмийн чиглэлд бид хүртээмжтэй оролцоог дэмжиж, ажилтнуудынхаа сэтгэл хангалуун байдлыг чухалчилдаг. Уян хатан бодлогоор ажил амралтын тэнцвэрийг хангахыг зорьж, ялгаатай байдал, оролцоог дэмжихийн зэрэгцээ эмэгтэйчүүд тэргүүлсэн бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийж, эдийн засгийн өсөлт, тэгш боломжийг бүрдүүлж байна.



Засаглалын түвшинд бид хариуцлагатай банкны үйл ажиллагааны үндэс болсон ёс зүйн дээд стандартыг мөрдөж, ил тод байдал, хариуцлага, эрсдэлийн зөв удирдлагыг хангаж ажилладаг. БОНЗ-ын зарчмуудыг бизнесийн стратегидаа нэвтрүүлснээр бид итгэлцлийг бий болгох, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, урт хугацааны амжилтыг бий болгоход чиглэж байна гэж үзэж байна.

2025 оны хагас жилийн байдлаар Богд Банк нь БОНЗ-ын зарчмуудыг бүх үйл ажиллагаандаа улам гүнзгий нэгтгэсээр, тогтвортой, хариуцлагатай, хөгжин дэвжсэн ирээдүйг хамтдаа бүтээхэд тууштай ажиллаж байна."

Хүндэтгэсэн,

Г.Саруул

Гүйцэтгэх захирал

Тогтвортой хөгжлийн тайлангийн тухай

2025 оны хагас жилийн Тогтвортой хөгжлийн тайлан нь 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацааг хамарсан бөгөөд Богд Банкны тогтвортой санхүү, байгаль орчны хамгаалал, нийгмийн хариуцлага, засаглалын (БОНЗ) хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлууд, ололт амжилтуудыг онцлон танилцуулж байна.

Энэхүү тайлан нь арван гурав гол сэдвүүдийг багтаасан бөгөөд тус бүрд нь манай амлалт, бизнес болон нийгэмд үзүүлэх ач холбогдол, одоог хүртэлх ахиц дэвшлийг тодорхойлон тусгасан болно.





Тогтвортой хөгжил



Бидний оролцоо

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, нийгмийн хариуцлага, ил тод байдлыг тэргүүлэх чиглэлээр баримталдаг.

Энэхүү чиглэлийн хүрээнд бид Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоонд нэгдэж, 2015 онд албан ёсны гишүүн болсон. Үүнээс хойш Богд Банк нь Тогтвортой хөгжлийн зорилгуудыг өдөр тутмын үйл ажиллагаа болон банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй нягт уялдуулан хэрэгжүүлсээр ирсэн билээ.

Банкны "Байгаль орчин, нийгмий хариуцлага, жендерийн эрх тэгш байдлын бодлого" -ын хүрээнд зээл олголтын үйл ажиллагаандаа тогтвортой санхүүгийн зарчмуудыг мөрдлөг болгож, байгаль орчин болон нийгмийн хариуцлагыг дэмжин ажиллаж байна. Мөн БОНЗ-ын бодлогын хүрээнд банк нь эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг хэрэгжүүлэх, ус болон цаасны хэрэглээг бууруулах, хог хаягдлыг дахин боловсруулах, бүх хэрэглэгчдэд хүртээмжтэй, тэгш оролцоог хангах үйлчилгээг үзүүлэхэд анхаарч ажиллаж байна.



Бидний оролцоо

Богд Банк нь ToC Холбооны 8 зарчмыг үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Жил бүр бид ToC-ийн хэрэгжилтийн тайланг боловсруулан ToC Холбоо-д хүргүүлдэг бөгөөд энэхүү тайланг Монголбанк болон Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) хамтран үнэлж, дүгнэлт гаргадаг.

Мөн Богд Банк нь ToC-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан тусгай ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсэгт банкны газар, нэгж бүрийн төлөөллүүд байдаг. Ингэснээр зөвхөн банкны ToC алба гэлтгүй бусад газар, нэгжүүд ч мөн адил тогтвортой байдалтай холбоотой мэдээ мэдээллийг цаг алдалгүй авж бусад ажилтнуудад түгээх боломжийг бий болгодог билээ.



Ногоон банк

Манай банкнаас санал болгож буй Ногоон Санхүүгийн Бүтээгдэхүүнүүд:



Эко автомашины зээл



Ногоон хэрэглээний зээл



Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл






Дулаалгын зээл

Ногоон санхүүжилт

Богд Банк нь Жижиг, дунд бизнес (ЖДҮ) болон ногоон зээл-ийг дэмжих зорилгоор хэд хэдэн хөгжлийн санхүүгийн байгууллага (DFI) болон хөрөнгө оруулагчдаас санхүүжилт амжилттай татан авч, үйл ажиллагаандаа тусгасан.

- 2022 оны 12 сар – DFC-ээс **15 сая ам.долларын** санхүүжилт авч, эмэгтэйчүүд тэргүүлсэн бизнесүүд болон ногоон салбарыг дэмжихэд чиглүүлсэн.
- 2023 оны 12 сар – DGGF-оос **8 сая ам.доллар** авч, эмэгтэйчүүд тэргүүлсэн ЖДҮ-үүдийг дэмжсэн.
- EMF-ээс нийт **17 сая ам.долларын** санхүүжилт авч, ЖДҮ-ийн хөгжлийг дэмжихэд зориулагдсан.
- ADB-аас **15 сая ам.долларын** санхүүжилт татан авч, ЖДҮ болон ногоон зээлд зориулсан.
- 2024 оны 8 сар – GGSF-оос **5 сая ам.долларын** санхүүжилт авч, эмэгтэйчүүд тэргүүлсэн ЖДҮ-үүдийг дэмжсэн.
- 2024 оны 12 сар – FMO байгууллагатай **20 сая ам.долларын** зээлийн шугамын гэрээ байгуулж, хөдөө аж ахуй, залуучууд, эмэгтэйчүүдийн ЖДҮ, ногоон төслүүдийг дэмжих зорилгоор ашиглаж эхэлсэн.





Байгаль орчин




Байгаль орчин



Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хэрэгжүүлж буй санаачилгынхаа хүрээнд бид Байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжих, Ногоон хэрэглээний зээл, Эко автомашины зээл зэрэг бүтээгдэхүүнээр дамжуулан хувь хүмүүсийн тогтвортой сонголтыг дэмжиж байна. Энэхүү зээлүүдээр дамжуулан бид байгаль орчны нөлөөллийг бууруулж, экологид ээлтэй хэрэглээг нэмэгдүүлэн, илүү ногоон ирээдүйг цогцлоохыг зорьж байлаа билээ.


Богд банк нь ногоон санхүүжилт, нөөцийн үр ашигтай хэрэглээ, байгальд ээлтэй үйл ажиллагааг тэргүүн зорилтоо болгон ажилласаар ирсэн билээ. Бид тогтвортой бизнесийг дэмжиж, хог хаягдлыг бууруулахын зэрэгцээ эрчим хүчний хэмнэлт болон дижитал шилжилтийг идэвхтэй дэмжин ажиллаж байна.



Ногоон санаачилгууд

"Тэрбум мод" сан




"Тэрбум мод" сангийн хүрээнд бид жил бүр мод тарьдаг бөгөөд 2025 оны 5-р сарын 8-ны өдөр Гачууртын эко цэцэрлэгт хүрээлэнд Арилжааны банкууд хамтран Тэрбум мод сангийн зохион байгуулалтан дор мод тарив.



2022 оноос хойш нийт ойролцоогоор **12,500** шилмүүст болон навчит мод тарьсан байна.

Дэлхийн байгаль орчны өдрүүд

Сар бүр дэлхийн байгаль орчны өдрүүдэд тохиолдуулан мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээж эхэлсэн.



Ногоон санаачилгууд

"GREEN OFFICE" аянг зохион байгуулав

Богд Банк дотооддоо анх удаа **"Green Office"** аяныг **2024 оны 6-р сарын 16-наас 7-р сарын 7-ны** хооронд амжилттай зохион байгууллаа.



"Санаачилга бүр өөрчлөлт авчирна" уриан дор зохион байгуулагдсан уг аяны үндсэн зорилго нь тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилт гэж юу болох талаар суурь мэдлэг олгох, энэ сэдвийн ач холбогдлыг ажилтнуудад ойлгуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд оршсон юм.



Ногоон санаачилгууд

"GREEN OFFICE" аянг зохион байгуулав

Аян долоо хоног бүр өөр өөр сэдвийг хамарч, мэдээ мэдээлэл түгээх, ажилтнуудыг идэвхжүүлэх сорилт (challenge) зарлах зэрэг олон төрлийн сонирхолтой, хүртээмжтэй арга хэмжээнүүдийг багтаасан. Энэхүү санаачилга нь тогтвортой байдлыг байгууллагын соёлын нэг хэсэг болгон төлөвшүүлэх чухал алхам боллоо.



Аяны хүрээнд хүрсэн гол үр дүн:

- Тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилтийн талаарх ойлголт нэмэгдсэн
- Ажилтнууд өөрсдийн хүлэмжийн хий ялгаруулалтыг тооцож сурах боломжтой болсон
- Хуванцар хэрэглээний талаарх мэдээлэл, бууруулах зөвлөмжүүд хүргэгдсэн
- Цаасны хэрэглээтэй холбоотой мэдээлэл, хэмнэх зөвлөмжүүд хүргэгдсэн
- “Ногоон санаа” сэдвийн хүрээнд ажилтнуудын оролцоог урамшуулсан
- Хуванцар хэрэглээг бууруулах зорилгоор ажил дээрээ хувийн аяга авчрах уриалга гаргасан
- Аянгийн үеэр хийгдсэн санал асуулгын үр дүнд ажилтнуудын дунд шинэ клуб үүсэх боломж гарж ирсэн.





Хүлэмжийн хийн ялгарал

Богд Банк нь 2025 оноос эхлэн The Partnership for Carbon Accounting Financials (PCAF) байгууллагын зөвлөмж, стандартын дагуу **1-р хүрээ** болон **2-р хүрээний** хүлэмжийн хийн ялгарлыг тооцож эхэлсэн билээ.

2025 оны хагас жилийн байдлаар **245.83 тонн** хүлэмжийн хийг ялгаруулаад байна.

Хүрээ 1 (Scope 1):

1-р хүрээ буюу Богд банкны хэмжээнд үйл ажиллагаагаараа шууд ялгаруулж буй хүлэмжийн хий 2025 оны хагас жилийн байдлаар 1.7 тонн байна.

Хүрээ 2 (Scope 2):

2-р хүрээ буюу Богд банкны бүх салбар нэгж, оффис, хаяг, цахилгаан машинуудыг цэнэглэх зэрэг цахилгааны хэрэглээнээс үүсэх ялгарлын хэмжээ 244.13 тонн байна.

Зарим тооцоолол хийхэд шаардлагатай өгөгдөл бүрэн бүрдээгүй байгаа тул энэхүү тооцооллын үр дүн нь ойролцоо үнэлгээ бөгөөд бодит ялгарлын хэмжээг бүрэн илэрхийлээгүй байж болзошгүй. Цаашид үнэлгээний өгөгдлийн нарийвчлалыг сайжруулахаар зорьж байна.



Нөөцийн хэмнэлт

Богд Банк нь өдөр тутмын үйл ажиллагаандаа байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах, байгууллагын нөөцийн хэрэглээг оновчтой зохион байгуулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Бичиг хэргийн хэрэглээний хяналт:

- Салбаруудын бичгийн цаасны сарын хэрэглээг тогтмол хянаж, харьцуулсан дүн шинжилгээ хийж эхэлсэн нь нөөцийн төлөвлөлтийг сайжруулахад тус болж байна.
- Бичгийн цаасны хэрэглээ болон принтерийн хорны зарцуулалтад хяналт тавих үүнээс зээлийн гаралт болон бусад мэдээллийг график хэлбэрээр харуулж, үр ашигтай байдалд дүн шинжилгээ хийж байна.
- Принтерийн хорны хэрэглээг хуудасны тоо болон граммын хэмжээнд тулгуурлан туршилт хийж, зохистой хэрэглээг бий болгохоор ажиллаж байна.



Тогтвортой хэрэглээний дадлыг төлөвшүүлэх нь

Уулзалт болон сургалтын үед нэг удаагийн аяга, хэрэгслийн хэрэглээг зогсоож, дахин ашиглагдах шаазан аяга, таваг тогтмол хэрэглэж эхэлсэн. Энэ нь хог хаягдлын хэмжээг бууруулах, тогтвортой хэрэглээг дэмжих чухал алхам болж байна.



Худалдан авалтын давхардлыг бууруулах зохицуулалт:

Сарын төсвийн худалдан авалтыг хэлэлцэхээс өмнө үлдэгдэл болон байгаа нөөцийг тогтоох журам нэвтрүүлснээр давхардсан худалдан авалтыг багасгаж, үр ашиггүй зардлыг бууруулсан.



БОГД БАНК

Удиртгал

Тогтвортой хөгжил

Байгаль орчин

Нийгэм

Засаглал

Нийгэм



Богд Банк Тогтвортой хөгжлийн тайлан 2025 оны хагас жил

Нийгэм



Богд Банк нь жижиг, дунд бизнесийн санхүүжилт, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, ногоон зээл, хөдөө орон нутгийн хөгжил, мөн дижитал шилжилтийг дэмжих замаар БОНЗ-ын санаачилгуудын хэрэгжүүлж нийгмийн нөлөөг бий болгохыг зорин ажиллаж байна.

Санхүүгийн боловсрол

“LEVEL UP хөтөлбөр

Ахлах ангийн сурагчдад зориулсан санхүүгийн боловсрол олгох “Level Up” арга хэмжээнд оролцож, хүүхдүүдийн мөнгөний мэдлэгийг дэмжсэн.



Санхүүгийн боловсролын видео контент

Залуучуудад зориулан санхүүгийн боловсрол өгөх зорилгоор шинээр видео контент хийж эхэлсэн байгаа ба 10/1-ийн дүрмээр хадгалаж эхлэх, өөрийн санхүүг зохицуулж сурах гэх зэрэг мэдээ мэдээллийг түгээж эхэлсэн.



Дэлхийн мөнгөний 7 хоног аян

“Санхүүгийн зөв шийдвэр – Маргаашийн амжилтын эхлэл” уриан дор Монгол Улсад 13 дахь жилдээ зохион байгуулагдсан дэлхийн мөнгөний аянд оролцсон. Сошиал орчин дахь санхүүгийн залилангаас хэрхэн сэргийлэх, эрсдэлтэй үед сэтгэл хөдлөлөө зөв удирдах талаар мэдээлэл хүргэсэн.



Нийгэм

Санхүүгийн хүртээмж ба урамшуулалт аянгууд

“Дурсамж түгээ” хадгаламжийн урамшуулалт аян

Хүүхдийн мөнгийг хуримтлал болгохыг уриалсан энэхүү аян нь гэр бүлийн санхүүгийн төлөвлөлтийг дэмжих зорилготой байсан бөгөөд аяны хүрээнд хадгаламж нээсэн харилцагчдад аяллын эрх бүхий урамшуулал олгосон. Уг урамшуулал нь санхүүгийн боловсролыг нэмэгдүүлж, хуримтлалын ач холбогдлыг олон нийтэд таниулахад чухал хувь нэмэр оруулсан юм.



“Итгэл” хадгаламжийн гарын бэлэгтэй урамшуулалт аян

Хуримтлалын дадлыг дэмжих зорилготой “Итгэл” аянаар дамжуулан шинэ хадгаламж нээсэн харилцагчдад бэлгийн урамшуулал олгож, санхүүгийн тогтвортой ирээдүйн төлөө хийх эхний алхмыг бий болгосон билээ. Энэхүү аян нь иргэдийг хуримтлал үүсгэх, өөрийн ирээдүйд итгэлтэй хандахад чиглэсэн бодит дэмжлэг болсон хэмээн үзэж байна.



Ажилтнуудын оролцоо ба дотоод соёл

Ажилтнуудын имэйл гарын үсэгт тогтвортой хөгжлийн уриалга оруулсан нь

Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд байгууллагын дотоод соёл, харилцааны хэлбэрийг байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай чиглэлд уялдуулах зорилгоор ажилтнуудын и-мэйлийн гарын үсэг (Signature) хэсэгт тогтвортой хөгжилд уриалсан товч сануулгыг нэмсэн. Энэ нь байгууллагын нийт ажилтнуудын өдөр тутмын харилцаанд ТоС-ийн үнэт зүйлсийг тусгах чухал алхам болж байна.

Нийгэм

Ажилтнуудын оролцоо ба дотоод соёл

“Тогтвортой байдлын” сонин

Байгууллагын дотоод соёлыг бэхжүүлэх зорилгоор сар бүрийн “Тогтвортой байдлын сонин”-г ажилтнуудад тогтмол хүргэж эхэлсэн.



Энэхүү сонин нь тогтвортой байдлын талаарх үндсэн ойлголт, өдөр тутмын хэрэглээтэй холбоотой зөвлөмж, шинэ нэр томьёо, урам өгсөн санаачилгууд болон ажилтнуудын “ногоон” туршлагыг хуваалцах “Богдын булан” зэрэг олон талт мэдээллийг багтаасан билээ.

Нийгэм

Олон нийтэд мэдээлэл түгээх

“Ногоон эрэл” сонин руу мэдээлэл хүргүүлэх

Байгууллагын байгаль орчин, нийгэм, засаглалыг (ESG) дэмжих үйл ажиллагааг олон нийтэд таниулах үүднээс **“Ногоон эрэл”** сонинд холбогдох мэдээллийг хүргүүлж, 6-р сарын дугаарт нийтлүүлэв.



Засаглал



Засаглал



Богд банк ил тод байдал, ёс зүйтэй банкны үйл ажиллагаа болон хариуцлагатай засаглалыг эрхэмлэдэг.

Бид санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлж, БОНЗ-ын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэгтгэн, ЖДҮ-үүдийг дэмжин ажиллаж байна. Цахим шилжилт болон тогтвортой санхүүгийн шийдлээр дамжуулан бид инновац, хүртээмжтэй хөгжил болон урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмждэг.

Төлөөлөн удирдах зөвлөл



Л.Болдхуяг

ТУЗ-ийн дарга, МУ-ын Гавъяат Эдийн Засагч

- Монголын санхүүгийн зах зээлд 25 гаруй жилийн туршлагатай, Боди корпорацийн хамтран үүсгэн байгуулагч
- Монгол Улсын томоохон арилжааны банкны ТУЗ-ийн гишүүн, даргаар ажиллаж байсан
- Шведийн Вант Улсын Хүндэт консул



Г.Саруул

Гүйцэтгэх захирла, ТУЗ-ийн гишүүн



Ж.Нарантуяа

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Жан Торстэн Дазер

ТУЗ-ийн гишүүн



Р. Баясгалан

ТУЗ-ийн гишүүн



Д.Моломжамц

ТУЗ-ийн гишүүн



Рожер Томас Мойес

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Б.Ойгонжаргал

ТУЗ-ийн гишүүн



Филипп Кахэн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Засаглал

Удирдлагын баг


Г.Саруул
Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн

- Санхүүгийн салбарт 20 гаруй жилийн туршлагатай
- Монголын Хөрөнгийн Биржийн дэд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан
- APM Futures болон Rosenthal Collins Group компанид Ази, Орос, ТУХН-ийн бүсийг хариуцсан захирлаар ажилласан
- Mobium Mortgage Group компанид ахлах банкирээр ажиллаж байсан


М.Алтанбагана
Бизнес банк хариуцсан захирал

М.Бат-Өлзий
Санхүү хариуцсан захирал

Б.Билэгт
Байгууллагын банк хариуцсан захирал

М.Алтанзүрх
Мэдээллийн технологи хариуцсан захирал

Ч.Банчин
Бизнес хөгжил хариуцсан захирал

Э.Ган-Эрдэнэ
Хөрөнгө зохицуулалт хариуцсан захирал

Богд банкны Тогтвортой байдлын бодлого ба хэрэгжилт

Богд банкны Байгаль орчин, Нийгмийн хариуцлага, Жендерийн тэгш байдлын бодлого нь 2022 онд батлагдаж, холбогдох үүрэг, зарчмуудыг тодорхойлсон. Энэхүү бодлогоор дамжуулан тогтвортой төсөл, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг дэмжиж, эдийн засгийн төрөлжилт, тогтвортой санхүүжилтэд хувь нэмэр оруулж байна.

Мөн байгаль орчин, нийгэм, жендерийн эрсдэлийг удирдах тогтолцоог бүрдүүлсэн ба энэ хүрээнд БОНЗ-ны эрсдэлийн үнэлгээ, удирдлагын журамыг батлан 2024 онд шинэчлэн баталсан.

2025 оны хагас жилийн хугацаанд ТУЗ-ийн түвшинд тогтвортой байдлыг хариуцах гишүүнийг томилж, анхны онлайн уулзалтаа амжилттай зохион байгуулав.

Засаглал

Ил тод байдал ба тайлагнал

БОНЗ-ын тайланг тогтмол хүргүүлж байна

Санхүүжилт татсан Олон Улсын санхүүгийн байгууллагуудад БОНЗ-той холбоотой шаардлага бүхий тайлан, маягт, мэдээллүүдийг цаг тухайд нь хүргүүлсэн.

Европын холбооны GGBI хөтөлбөрт зориулсан One Pager бэлтгэсэн

GGBI хөтөлбөрт оролцох зорилгоор богино хэмжээний танилцуулга (One Pager)-г бэлтгэж, байгууллагын ногоон, тогтвортой санхүүгийн чиглэлийг товч тодорхой байдлаар бэлтгэн хүргүүлсэн.



2024 оны Тогтвортой байдлын тайланг англиар боловсруулсан

Байгууллагын тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагааг олон улсын түвшинд танилцуулах зорилгоор 2024 оны тогтвортой хөгжлийн тайланг англи хэл дээр боловсруулсан.




Засаглал

Байгууллагын дотоод чадавхийг хөгжүүлэх


ТоС сургалтын гарын авлага боловсруулсан

Тогтвортой хөгжлийн үндсэн ойлголт, БОНЗ-ын агуулгыг багтаасан сургалтын гарын авлагыг боловсруулан ажилтнуудад хүргэж эхэлсэн.



Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээ

Байгууллагын 2022 оноос 2024 он хүртэлх хийсэн ажлуудыг нэгтгэн боловсруулж БОНЗ-ын хүрээг анх удаа англи хэл дээр бэлтгэсэн.





БОГД БАНК

Тогтвортой хөгжлийн тайлан
2025 оны хагас жил